

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ХОРШООДЫН 2010 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2011.02.22

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант онд Хорооны хуралдаанаар 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 35 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 15 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 4 хоршооны тусгай зөвшөөрлийг сэргээхээр шийдвэрлэж 2010 оны жилийн эцсийн байдлаар нийт 179 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байна.


Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй хоршоодоос 147 буюу нийт хоршооны 82.1 хувь нь зохих журмын дагуу 2010 оны жилийн эцсийн санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг ирүүлсэн, 32 буюу 17.9 хувь нь ирүүлбэл зохих тайлан мэдээг хугацаанд нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүйгээс, тэдгээр хоршоодын Хороонд ирүүлсэн сүүлийн улирлын санхүүгийн тайлангаар нэгтгэлд хамрууллаа.

Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлсэн 147 хоршооны тайлан мэдээг ирүүлсэн хугацаагаар нь авч үзвэл журмын дагуу хугацаандаа ирүүлсэн 74 хоршоо, 10 хүртэл хоног хоцроосон 48 хоршоо, 11-20 хүртэл хоног хоцроосон 22 хоршоо, 21 дээш хоног хоцроосон 3 хоршоо байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа байдлыг харуулбал дараах байдалтай байна.



Хоршоодын гишүүдийн тоог графикаар үзүүлбэл:



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо тайланд онд буурсантай холбоотойгоор гишүүдийн тоо 2079 гишүүнээр буурсан хэдий ч нэг хоршоонд элссэн гишүүдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Харин 2010 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангаа ирүүлээгүй 32 хоршооны нэгтгэлд хамруулсан санхүүгийн тайланг цаг хугацааны хувьд нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлант хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2009-III	1	Баянлхам
2	2009-IV	6	Наранховаат, Бидний хөтөч, Очир төр, Дөргөн хөгжил, Манхан хөгжил, ЯАХ
3	2010-I	2	Фрейндс инвест, Зоос өртөө
4	2010-II	6	Си Ди Ко, Хяргас хас, Өгөөмөр хас, Говийн чимэг, Алтан нийлбэр, Рашааны далай
5	2010-III	17	Элли, Говийн буян дэлгэрэх, Тэгш уран санаа, Тонхил хөгжил, Ландо, Анхдагч андууд, ТДМ, Гэрэг инвест, Партизаны тэнхлэг, Зуун пенни, Арвижих хас, Баянхайрхан хас, Хамтын хөгжлийн чуулган, Их наяд кредит, Хатадын булаг, Песо, Транс инвест
Нийт		32	

Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Онууд	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл					Хоршоодын тоо
	шинээр олгосон	хүчингүй болгосон	түдгэлзүүлсэн	түдгэлзүүлснийг сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	
2006	51	0	0	-	-	51
2007	128	0	0	-	-	179
2008	45	15	5	-	-	209
2009	15	12	8	1	25	212
2010	2	35	15	4	80	179

ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал	2009 оны IV улирал
1	ХЗХ-дын тоо	179	212
2	Гишүүдийн тоо	25,990	28,069
3	Нийт актив /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	48,802,256.4 0.8%	44,568,177.8 1.00%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	34,860,950.1 1.1%	32,215,209.7 1.20%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	3,533,893.3 1.0%	2,128,058.1 0.50%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	34,778,632.0 1.3%	29,898,255.7 1.70%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	7,357,425.1 3.0%	7,442,560.6 2.80%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл /мян.төг/ Банкны салбарт эзлэх хувь	3,859,421.3 3.0%	4,469,339.6 1.90%
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	452,266.3	601,225.9
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	230,586.9	209,460.7

11	Нийт орлого /мян.төг/	12,505,560.7	14,527,593.3
12	Нийт зардал /мян.төг/	11,022,662.0	12,690,728.1
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	1,482,898.7	1,836,865.20
14	Активын өгөөж /ROA/	5.33%	4.81%
15	Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	19.04%	15.42%

2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	74
2	Гишүүдийн тоо	11,056
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	42.5%
3	Нийт актив /мян.төг/	42,058,582.4
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	86.2%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	29,708,478.8
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	85.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	2,956,711.1
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	83.7%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	31,773,715.6
	ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	91.4%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	5,215,324.1
	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	70.9%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүнд /мян.төг/	3,146,462.7
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	81.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүнд /мян.төг/	66,936.8
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүнд /мян.төг/	5,915.4
11	Нийт орлого /мян.төг/	10,569,685.7
12	Нийт зардал /мян.төг/	9,558,718.7
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	1,010,967.1

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 74 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 41.3 хувийг, тэдгээрийн нийт актив 42,058,582.4 мянган төгрөг байгаа нь нийт активын 86.2 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 74 хоршоо нь 10,569,685.7 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 84.5 хувийг, харин 9,558,718.7 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 86.7 хувийг тус тус эзэлж байна.


2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	105
2	Гишүүдийн тоо	14,934
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	57.5%
3	Нийт актив /мян.төг/	6,743,674.0
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	13.8%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	5,152,471.2
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	14.8%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	577,182.3
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	16.3%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	3,004,916.4
	ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	8.6%

7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	2,142,101.0
	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	29.1%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	712,958.7
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	18.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	385,329.5
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	224,671.5
11	Нийт орлого /мян.төг/	1,935,874.9
12	Нийт зардал /мян.төг/	1,463,943.3
13	Тухайн үеийн ашиг /мян.төг/	471,931.6

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 105 хоршоо нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хоршоодын 58.7 хувийг, тэдгээрийн нийт актив 6,743,674.0 мянган төгрөг байгаа нь нийт активын 13.8 хувийг тус тус эзэлж байна.

Эдгээр 105 хоршоо нь 1,935,874.9 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь нийт хадгаламж, зээлийн хоршоодын орлогын 15.5 хувийг, харин 1,463,943.3 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт хоршоодын зардлын 13.3 хувийг тус тус эзэлж байна.



2.3 Хасбанкны франчайзийн гэрээтэй ажиллаж буй хоршоодын статистик үзүүлэлтүүд

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал
1	Хас банктай франчайзийн үйлчилгээний гэрээтэй ХЗХ-дын тоо	65
2	Гишүүдийн тоо	9,388
	ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь	36.1%
3	Нийт актив /мян.төг/	3,429,419.0
	ХЗХ-ны нийт активт эзлэх хувь	7.0%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мян.төг/	2,663,147.0
	ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	7.6%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл /мян.төг/	94,167.5
	ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь	2.7%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл /мян.төг/	937,893.7
	ХЗХ-ны нийт татсан хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь	2.7%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө /мян.төг/	1,341,494.0
	ХЗХ-ны нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь	18.2%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн /мян.төг/	481,932.2
	ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь	12.5%
9	Нийт банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн /мян.төг/	385,217.7

10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн /мян.төг/	203,674.2
11	Нийт орлого /мян.төг/	1,073,154.5
12	Нийт зардал /мян.төг/	737,680.8
13	Тухайн үеийн ашиг, алдагдал /мян.төг/	335,473.7

Хасбанктай франчайзийн гэрээтэй 65 хоршоо үйл ажиллагаа явуулж байна. Тайлант улиралд Хасбанкнаас үйл ажиллагаа нь хэвийн явагдахгүй байгаа цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон хоршоодын хүсэлтийг үндэслэн Завхан аймгийн Идэр сэрвэн, Дархан-Уул аймгийн Хас итгэл, Архангай аймгийн Ач-эх зэрэг 3 хоршооны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны хуралдаанаар хүчингүй болгосон. Харин Дорноговь аймгийн Саруул-баян хоршоо Хасбанктай франчайзийн гэрээгээ цуцалсан байна.

Франчайзийн гэрээтэй хоршоодын орлого, зарлагын тайлангаас харахад 1.073.154.5 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт орлогын 8.6 хувийг, харин 737.680.8 мянган төгрөгийн зардал нь нийт зардлын 6.7 хувийг эзэлж байна. Тайлант улиралд 335,473.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

ГУРАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Орлогын үзүүлэлтүүд

Тайлант жилд нийт орлогын хэмжээ 12,505,560.7 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,022,032.7 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар буурсан нь Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр гишүүдээс гадаад валютаар хадгаламж татан төвлөрүүлэх, гадаад валютаар зээл олгохыг хориглосонтой холбоотойгоор гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого өмнөх оны мөн үеэс 2,290,047.9 мянган төгрөгөөр буюу 78.7 хувиар буурсантай холбоотой байна.

Орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд

/мянган төгрөгөөр/

	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ОРЛОГО	11,171,397.4	89.3%	10,764,213.8	74.1%	407,183.6	3.8%
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	10,570,630.9	84.5%	10,218,971.7	70.3%	351,659.2	3.4%
Зээлийн нэмэгдүүлсэн хүү, алдангийн орлого	146,456.2	1.2%	193,878.8	1.3%	- 47,422.6	-24.5%
Банкнаас авсан харилцах, хадгаламжийн хүүгийн орлого	365,024.9	2.9%	330,395.0	2.3%	34,629.9	10.5%
Бусад байгууллагаас авсан хүүгийн орлого	18,940.2	0.2%	2,649.4	0.0%	16,290.8	0.0%
Бусад хүүгийн орлого	70,345.1	0.6%	18,318.9	0.1%	52,026.3	284.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	379,424.7	3.0%	674,231.9	4.6%	- 294,807.2	-43.7%
Элсэлтийн хураамж	8,901.3	0.1%	11,093.2	0.1%	- 2,191.8	-19.8%
Гишүүний татвар	22,846.3	0.2%	22,152.8	0.2%	693.5	3.1%
Үйлчилгээний хураамж	98,147.3	0.8%	146,521.1	1.0%	- 48,373.9	-33.0%
Үйл ажиллагааны бусад орлого	249,529.8	2.0%	494,464.8	3.4%	-244,935.0	-49.5%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	954,738.5	7.6%	3,089,147.6	21.3%	- 2,134,409.1	-69.1%
Торгуулийн орлого	-	0.0%	5,881.3	0.0%	- 5,881.3	-100.0%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын орлого	23,558.2	0.2%	12,949.9	0.1%	10,608.2	81.9%
ӨБҮХХ борлуулснаар олсон орлого	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	618,536.8	4.9%	2,908,584.6	20.0%	- 2,290,047.9	-78.7%
Тэнцлийн гадуурх тооцооноос орсон орлого	42,250.9	0.3%	1,341.0	0.0%	40,909.9	3050.7%
Бусад орлого	205,488.8	1.6%	147,926.3	1.0%	57,562.5	38.9%
Онцгой шинжтэй орлого	60,231.3	0.5%	10,323.0	0.1%	49,908.3	483.5%

Ердийн бус орлого	4,672.7	0.0%	2,141.4	0.0%	2,531.2	118.2%
Нийт орлогын дүн	12,505,560.7	100.0%	14,527,593.3	100.0%	- 2,022,032.7	-13.9%

Тайлант жилд нийт орлогын 89.3 хувийг зээлийн хүүгийн орлого, 7.6 хувийг үйл ажиллагааны бус орлого, 3.0 хувийг элсэлтийн хураамж, гишүүний татвар, үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны бусад эзэлж байна.

3.2 Зардлын үзүүлэлтүүд

Тайлант жилд нийт зардлын хэмжээ 11,022,662.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,668,066.1 мянган төгрөгөөр буюу 13.1 хувиар буурсан ба үүнд үйл ажиллагааны бус зардлын өөрчлөлт нөлөөлжээ.

Зардал дараах бүтэцтэй байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ	Дүн	ХУВЬ
ХҮҮГИЙН ЗАРДАЛ	6,361,025.7	57.7%	6,169,097.9	60.3%	191,927.9	3.1%
Хугацаагүй хадгаламжийн хүүгийн зардал	2,565,060.1	23.3%	2,510,039.5	24.5%	55,020.5	2.2%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1 жил хүргэлх хугацаатай)	3,099,564.2	28.1%	3,262,011.9	30.4%	-162,447.8	-5.0%
Хугацаатай хадгаламжийн хүүгийн зардал (1-ээс дээш жилийн хугацаатай)	523,899.9	4.8%	221,232.2	1.3%	302,667.7	136.8%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	132,767.4	1.2%	146,066.9	4.0%	-13,299.5	-9.1%
Бусад хүүгийн зардал	39,734.2	0.4%	29,747.3	0.1%	9,987.0	33.6%
БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	1,264,954.6	11.5%	802,734.5	9.5%	462,220.1	57.6%
Зээлийн болзошгүй эрсдэлийн зардал	1,220,225.7	11.1%	794,962.7	9.4%	425,263.0	53.5%
Авлагын болзошгүй эрсдэлийн зардал	2,603.2	0.0%	3,299.4	0.1%	- 696.2	-21.1%
Өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	40,388.6	0.4%	3,502.1	0.0%	36,886.5	1053.3%
Бусад эрсдэлийн зардал	1,737.1	0.0%	970.3	0.0%	766.8	79.0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,138,383.5	19.4%	2,264,221.3	21.9%	- 125,837.8	-5.6%
Боловсон хүчний зардал	1,301,338.1	11.8%	1,282,343.2	11.7%	18,994.9	1.5%
Бусад зардал	837,045.4	7.6%	981,878.2	10.2%	- 144,832.7	-14.8%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	1,258,298.1	11.4%	3,454,674.4	8.3%	-2,196,376.3	-63.6%
Торгуулийн зардал	10,218.0	0.1%	13,992.5	0.1%	-3,774.6	-27.0%
Ногдол ашгийн зардал	3,870.0	0.0%	4,006.3	0.2%	-136.3	-3.4%
Үндсэн хөрөнгийн түрээс, борлуулалтын гарз	1,117.3	0.0%	1,794.4	0.0%	-677.1	-37.7%
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал	968,286.5	8.8%	2,891,684.4	5.5%	-1,923,397.9	-66.5%
Үйл ажиллагааны бус бусад зардал	30,644.2	0.3%	299,336.3	0.3%	-268,692.2	-89.8%
Ердийн бус зардал	129.7	0.0%	5,400.2	0.0%	- 5,270.5	-97.6%
Татварын зардал	244,032.5	2.2%	238,460.2	2.2%	5,572.3	2.3%
Нийт зардлын дүн	11,022,662.0	100.0%	12,690,728.1	100.0%	- 1,668,066.1	-13.1%

Зардлын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон. Тухайлбал; хүүгийн зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 60.3-57.7 хувь болж буурсан, харин хүүгийн бус зардлын нийт зардалд эзлэх хувийн жин 8.3-11.4 хувь болж өссөн байна.

Нийт зардлын 57.7 хувийг хүүгийн зардал, 19.4 хувийг үйл ажиллагааны зардал, 11.4 хувийг үйл ажиллагааны бус зардал, 11.5 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал эзэлж байна. Харин нийт зардлын 8.8 хувийг гадаад валютын ханшийн тэгшитгэлийн зардал эзэлж *ХЗХ-дын 2010 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга*

байгаа бөгөөд энэ зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,923,397.9 мянган төгрөгөөр буюу 66.5 хувиар буурсан байна.

3.3 Алдагдалтай ажиллаж буй хоршоод

Тайлант жилд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын 14.5 хувь буюу 26 хоршоо нийт 378,698.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

д/д	Үзүүлэлтүүд	Хоршоодын тоо	Нийт алдагдал	Эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	1	252,856.7	66.8%
2	10,000.0-100,000.0 мянган төгрөг	3	57,772.9	15.3%
3	1,000.0-10,000.0 мянган төгрөг	11	33,254.4	8.8%
4	100.0-1,000.0 мянган төгрөг	10	4,774.1	1.3%
5	100.0 мянган төгрөг хүртэл	1	30.0	7.9%
	Нийт дүн	26	348,688.1	100.0%

Нийт алдагдалтай ажиллаж байгаа хоршоодын 57.7 хувь буюу 15 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн алдагдал 308,449.5 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 88.5 хувийг эзэлж байна.

Орон нутагт алдагдалтай ажиллаж байгаа 11 хоршооны 40,238.6 төгрөгийн алдагдал нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт алдагдлын 11.5 хувийг, үүнээс, Хасбанктай франчайзийн гэрээтэй 7 хоршоо нийт 10,505.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй алдагдалтай ажилласан хоршоодын нийт алдагдлын 26.1 хувийг эзэлж байна. Эдгээр хоршоодын зээлийн чанар муудсан нь алдагдалтай ажиллахад ихээр нөлөөлсөн.

3.4 Ашигтай ажиллаж буй хоршоод

Тайлант жилд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэж буй нийт хоршоодоос 153 хоршоо буюу 85.5 хувь нь 1,831,586.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан.

Ашгийн хэмжээгээр хоршоодыг ангилгахад дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Ашгийн үзүүлэлтүүд	Хоршооны тоо	Нийт ашиг	Ашигт эзлэх хувь
1	100,000.0 мянган төгрөгөөс дээш	4	879,668.8	48.0%
2	50,000.0-100,000.0 мянган төгрөг	1	85,305.7	4.7%
3	10,000.0-50,000.0 мянган төгрөг	22	551,146.7	30.1%
4	5,000.0-10,000.0 мянган төгрөг	19	130,550.7	7.1%
5	1,000.0-5,000.0 мянган төгрөг хүртэл	60	164,042.0	9.0%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	46	20,872.9	1.1%
7	Ашиг, алдагдалгүй	1		0.0%
		153	1,831,586.8	100.0%

Нийт ашигтай ажиллаж байгаа хоршоодын 38.6 хувь буюу 59 хоршоо нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа, тэдгээрийн ашиг 1,319,416.6 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 72.0 хувийг эзэлж байна.

Орон нутагт ашигтай ажиллаж байгаа 94 хоршооны ашиг 512,170.2 мянган төгрөг нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын нийт ашгийн 28.0 хувийг, үүнээс Хасбангтай франчайзийн гэрээтэй 58 хоршоо нийт 345,979.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь орон нутагт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ашигтай ажилласан хоршоодын нийт ашгийн 67.6 хувийг эзэлж байна.

ДӨРӨВ. АКТИВЫН ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Активын чанар

Хоршоодын тайлант жилийн нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:


ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	47,511,257.4	97.4%	43,101,802.1	96.7%	4,409,455.3	10.2%
МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,504,320.3	23.6%	9,779,467.7	21.9%	1,724,852.6	17.6%
1.Касс дахь бэлэн мөнгө	1,461,168.5	3.0%	1,580,187.5	3.5%	(119,019.1)	-7.5%
2.Банкинд байршуулсан харилцах	6,555,960.2	13.4%	4,466,616.2	10.0%	2,089,343.9	46.8%
3.Банкинд байршуулсан хадгаламж	3,487,191.6	7.1%	3,732,663.9	8.4%	(245,472.2)	-6.6%
4.Бусад байгууллагад байршуулсан харилцах	-	0.0%	0.0	0.0%	-	0.0%
5.Бусад байгууллагад байршуулсан хадгаламж	-	0.0%	-	0.0%	-	0.0%
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	32,325,996.4	66.2%	30,368,474.9	68.1%	1,957,521.5	6.4%
8. Нийт зээл	34,860,950.1	71.4%	32,215,209.7	72.3%	2,645,740.4	8.2%
8.1.Хэвийн зээл	29,222,802.3	59.9%	25,615,400.7	57.5%	3,607,401.7	14.1%
8.2.Хугацаа хэтэрсэн зээл	2,104,254.4	4.3%	4,471,750.9	10.0%	(2,367,496.5)	-52.9%
8.3.Чанаргүй зээл	3,533,893.3	7.2%	2,128,058.1	4.8%	1,405,835.2	66.1%
8.3.1. Хэвийн бус	883,242.8	1.8%	314,024.8	0.7%	569,218.0	181.3%
8.3.2. Эргэлзээтэй зээл	838,384.2	1.7%	491,661.5	1.1%	346,722.8	70.5%
8.3.3. Муу зээл	1,812,266.2	3.7%	1,322,371.8	3.0%	489,894.4	37.0%
8.4.(Зээлийн эрдэлийн сан)	2,534,953.6	5.2%	1,846,734.7	4.1%	688,218.9	37.3%
АВЛАГА (ЦЭВРЭЭР)	2,940,100.0	6.0%	2,276,296.3	5.1%	663,803.7	29.2%
9. Байгууллага, хүмүүсээс авах авлага	393,700.5	0.8%	222,984.90	0.5%	170,715.6	76.6%
10. (Байгууллага, хүмүүсээс авах авлагын эрдэлийн сан)	35,021.4	0.1%	50,355.10	0.1%	(15,333.7)	-30.5%
11. Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,581,420.9	5.3%	2,103,666.54	4.7%	477,754.4	22.7%
БУСАД ХӨРӨНГӨ	184,328.8	0.4%	162,388.6	0.4%	21,940.2	13.5%
12. Материал үнэ бүхий зүйл	119,693.7	0.2%	122,715.5	0.3%	(3,021.8)	-2.5%
14. Урьдчилж төлсөн зардал, тооцоо	8,731.3	0.0%	7,361.3	0.0%	1,370.0	18.6%
15. Бусад актив	55,903.7	0.1%	32,311.7	0.1%	23,592.0	73.0%
ӨМЧЛӨХ БУСАД ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	556,511.9	1.1%	515,174.6	1.2%	41,337.3	8.0%
16. Өмчлөх бусад хөрөнгө	640,917.3	1.3%	565,182.5	1.3%	75,734.8	13.4%
17. (Өмчлөх бусад хөрөнгийн эрдэлийн сан)	84,405.4	0.2%	50,008.0	0.1%	34,397.4	68.8%
2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	1,290,999.1	2.6%	1,466,375.7	3.3%	(175,376.7)	-12.0%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ (ЦЭВРЭЭР)	1,202,297.2	2.5%	1,356,635.8	3.0%	(154,338.6)	-11.4%
18. Үндсэн хөрөнгө	1,623,931.5	3.3%	1,860,980.4	4.2%	(237,049.0)	-12.7%
19.(Үндсэн хөрөнгийн элэгдэл)	421,634.3	0.9%	504,344.6	1.1%	(82,710.4)	-16.4%
БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	88,701.9	0.2%	109,739.9	0.2%	(21,038.1)	-19.2%
20. Биет бус хөрөнгө	22,097.0	0.0%	31,128.7	0.1%	(9,031.7)	-29.0%
21.Бусад	66,604.9	0.1%	78,611.3	0.2%	(12,006.4)	-15.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (1+2)	48,802,256.4	100.0%	44,568,177.8	100.0%	4,234,078.6	10.1%

Тайлант жилд активын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс эх үүсвэр 4,234,078.6 мянган төгрөг буюу 10.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор өссөн байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал; Чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувийн жин 4.8-7.2 хувиар өссөн харагдаж байгаа хэдий ч нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2,645,740.4

мянган төгрөгөөр өссөнтэй харьцуулахад зээлийн чанар сайжирсан харагдаж байна. Харин хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 4.7-5.3 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.

Харин хоршоодын активын бүтцийг авч графикаар харуулбал дараах байдалтай байна.



Активын төвлөрлийн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Активын хэмжээ	Хоршоодын тоо	Нийт актив	Нийт активт эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	18,851,047.0	38.6%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	6	14,482,174.4	29.7%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	7	4,465,603.6	9.2%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	34	7,086,437.9	14.5%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	26	1,909,809.6	3.9%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	72	1,800,349.0	3.7%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	23	174,072.4	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хуртэл	10	32,762.5	0.1%
	Нийт дүн	179	48,802,256.4	100.0%

Активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 500,000.0-18,851,047.0 мянган төгрөгийн активтай нийт 14 хоршооны нийт актив 37,798,824.9 мянган төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт активын 77.5 хувийг эзэлж байна.

Дээрх томоохон активтай 14 хоршооноос Номин юнион, Сидан, Алтан давалгаа, Май капитал, Есөн дэлбээ, Очир ундраа инвест, Финком, Мон сант алдар, Монум, Кредит юнион монгол, Цэнгэл хөгжил зэрэг 11 хоршоо тайлант улиралд 1,132,112.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт ашгийн 61.8 хувийг, Монгол газар гоулд, Зоосон мөнгө зэрэг 2 хоршоо 253,073.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын нийт алдагдлын 72.6 хувийг тус тус эзэлж байна. Харин Монкорд хоршоо ашиг ч үгүй, алдагдал ч үгүй ажилласан байна.

2010 оны жилийн эцсийн байдлаарх хадгаламж, зээлийн хоршоодын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр нийт актив 48.8 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын

нийт активын 0.8 хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн активын өсөлтийг дараах графикаас харж болохоор байна.



4.2 Зээлийн багцын чанар


Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:
/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31		2009.12.31		ӨӨРЧЛӨЛТ	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	32,325,996.4		30,368,474.9		1,957,521.5	6.4%
Нийт зээл	34,860,950.1	100.0%	32,215,209.7	100.0%	2,645,740.4	8.7%
Хэвийн зээл	29,222,802.3	83.8%	25,615,400.7	79.5%	3,607,401.7	11.9%
Хугацаа хэтэрсэн зээл	2,104,254.4	6.0%	4,471,750.9	13.9%	(2,367,496.5)	-7.8%
Чанаргүй зээл	3,533,893.3	10.1%	2,128,058.1	6.6%	1,405,835.2	4.6%
Хэвийн бус	883,242.8	2.5%	314,024.8	1.0%	569,218.0	1.9%
Эргэлзээтэй зээл	838,384.2	2.4%	491,661.5	1.5%	346,722.8	1.1%
Муу зээл	1,812,266.2	5.2%	1,322,371.8	4.1%	489,894.4	1.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,534,953.6		1,846,734.7		688,218.9	2.3%

Тайлант жилд нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 688,218.9 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 2,367,496.5 мянган төгрөг буюу 7.8 хувиар буурч нийт зээлийн багцын 6.0-13.9 хувийг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1,405,835.2 мянган төгрөг буюу 4.6 хувиар буурч, нийт зээлийн багцын 6.6-10.1 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн багцыг графикаар харуулбал:



Зээлийн багцын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт 2,645.4 мянган төгрөг буюу 8.7 хувиар өссөн. Харин зээлийн болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хэмжээ нийт актив хөрөнгийн 3.9 хувийг эзэлж байна.

Хоршоодын зээлийн өрийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Зээлийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт зээлийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	12,200,182.7	35.0%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	8,069,072.6	23.1%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	6	4,609,936.4	13.2%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	27	6,011,581.5	17.2%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	28	2,088,800.7	6.0%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	73	1,677,271.1	4.8%
7	5,000.0-10,000.0 мянган төгрөг	20	140,895.0	0.4%
8	5,000.0 мянган төгрөг хүртэл	21	63,210.1	0.2%
	Нийт зээлийн өрийн үлдэгдлийн дүн	179	34,860,950.1	100.0%

Зээлийн өрийн үлдэгдлийг ангилахад ихээхэн хэмжээний буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш зээлийн өрийн үлдэгдэлтэй нийт 10 хоршооны зээлийн өрийн үлдэгдэл 24,879,191.7 мянган төгрөг байгаа нь нийт хоршоодын олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 71.4 хувийг эзэлж байна. Ихээхэн хэмжээний зээлийн үлдэгдэлтэй 10 хоршоодын мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

д/д	Хоршоодын нэр	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	Нийт зээлд эзлэх хувь
1	Номин юнион	12,200,182.7	35.0%
2	Монкорд	4,380,318.8	12.6%
3	Сидан	1,992,102.4	5.7%
4	Монгол газар гоулд	1,696,651.3	4.9%
5	Май капитал	991,467.0	2.8%
6	Есөн дэлбээ	917,195.9	2.6%
7	Алтан давалгаа	850,552.3	2.4%

8	Кредит юнион монгол	710,804.3	2.0%
9	Мон сант алдар	570,712.8	1.6%
10	Финком	569,204.1	1.6%
	Нийт дүн	24,879,191.7	71.4%
	Бусад169 хоршоо	9,981,758.4	28.6%
	Нийт зээлийн дүн	34,860,950.1	100.0%

ТАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Хоршоодын тайлант жилийн нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Тухайлбал;

/мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2010.12.31		2009.12.31		Өөрчлөлт	
	Дүн	хувь	Дүн	хувь	Дүн	хувь
1. ӨР ТӨЛБӨР	37,585,410.0	77.0%	32,656,277.7	73.3%	4,929,132.3	10.70%
ХАДГАЛАМЖ	34,778,632.0	71.3%	29,898,255.7	67.1%	4,880,376.2	16.32%
1. Хугацаагүй	1,335,754.8	2.7%	1,905,561.9	4.3%	- 569,807.2	-29.90%
2. Хугацаатай	33,442,877.2	68.5%	27,992,693.8	62.8%	5,450,183.4	19.47%
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	452,266.3	0.9%	601,225.9	1.3%	- 148,959.6	-24.78%
3. Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл	348,439.6	0.7%	598,977.7	1.3%	- 250,538.2	-41.83%
4. Богино хугацаат төслийн санхүүжилт	103,826.8	0.2%	2,248.2	0.0%	101,578.6	4518.22%
БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,123,924.7	4.4%	1,947,335.3	4.4%	176,589.4	9.07%
5. Татварын төлөх өглөг	92,411.1	0.2%	89,288.3	0.2%	3,122.8	3.50%
6. Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,926,525.7	3.9%	1,690,643.0	3.8%	235,882.7	13.95%
7. Өглөг	84,463.7	0.2%	110,796.2	0.2%	- 26,332.6	-23.77%
8. Бусад пассив	20,524.2	0.0%	56,607.7	0.1%	- 36,083.5	-63.74%
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	230,586.9	0.5%	209,460.7	0.5%	21,126.2	10.09%
8. Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээл	230,586.9	0.5%	209,460.7	0.5%	21,126.2	10.09%
9. Урт хугацаат төслийн санхүүжилт	-	-	-	0.0%	-	-
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	11,216,846.5	23.0%	11,911,900.1	26.7%	- 695,053.7	-14.79%
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ	7,357,425.1	15.1%	7,442,560.6	16.7%	- 85,135.4	-1.14%
10. Хувь нийлүүлсэн хөрөнгө	7,357,425.1	15.1%	7,442,560.6	16.7%	- 85,135.4	-1.14%
ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	3,859,421.3	7.9%	4,469,339.6	10.0%	- 609,918.2	-13.65%
11. Нөөцийн сан	1,497,637.3	3.1%	1,179,211.9	2.6%	318,425.4	27.00%
12. Дахин үнэлгээний сан	269,480.8	0.6%	346,608.1	0.8%	- 77,127.3	-22.25%
13. Нийгмийн хөгжлийн сан	210,819.1	0.4%	136,726.6	0.3%	74,092.5	54.19%
14. Бусад сангууд	82,611.1	0.2%	74,602.5	0.2%	8,008.5	10.73%
15. Хандив, тусламж	42,985.6	0.1%	57,271.1	0.1%	- 14,285.5	-24.94%
16. Бусад өмч	54,314.5	0.1%	18,247.4	0.0%	36,067.1	197.66%
17. Тайлангийн үеийн ашиг/алдагдал	1,482,898.7	3.0%	1,836,865.2	4.1%	- 353,966.5	-19.27%
18. Хуримтлагдсан ашиг/алдагдал	218,674.2	0.4%	819,806.6	1.8%	- 601,132.4	-73.33%
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ДҮН (1+2)	48,802,256.4	100.0%	44,568,177.8	100.0%	4,234,078.6	9.50%

Тайлант жилд өмнөх оны мөн үеэс гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,880,376.2 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн, хоршоологчдын өмчийн хэмжээ 609,918.2 мянган төгрөгөөр буюу 13.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Хоршоологчдын өмчийн бууралтад өмнөх үеийн хуримтлагдсан ашгийн хэмжээ 601,132.4 мянган төгрөгөөр, тайлант үеийн хуримтлагдсан ашгийн хэмжээ 353,966.5 мянган төгрөгөөр тус тус буурсан, нөөцийн сангийн хэмжээ 318,425.4 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар өссөн нь нөлөөлсөн. Харин хугацаагүй хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс буурсан байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанд эерэгээр нөлөөлсөн гэж дүгнэж байна.

Харин банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээл, урт хугацаат өр төлбөрийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 127,833.4 мянган төгрөгөөр буюу 14.69 хувиар буурчээ.

Хоршоодын татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

/мянган төгрөгөөр/

д/д	Хадгаламжийн дүн /интервалаар/	Хоршоодын тоо	Нийт хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	10,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	15,052,808.3	43.3%
2	1,000,000.0-10,000,000.0 мянган төгрөг	3	9,803,405.5	28.2%
3	500,000.0-1,000,000.0 мянган төгрөг	6	4,016,627.7	11.5%
4	100,000.0-500,000.0 мянган төгрөг	17	3,654,368.3	10.5%
5	50,000.0-100,000.0 мянган төгрөг	12	893,000.2	2.6%
6	10,000.0-50,000.0 мянган төгрөг	49	1,189,787.0	3.4%
7	1,000.0-10,000.0 мянган төгрөг	41	161,855.3	0.5%
8	1,000.0 мянган төгрөг хүртэл	19	6,779.7	0.0%
9	Хадгаламжгүй	31		
	Нийт дүн	179	34,778,632.0	100.0%

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад томоохон буюу 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй нийт 10 хоршооны нийт хадгаламжийн үлдэгдлийн хэмжээ 28,872,841.6 мянган төгрөг нь хоршоодын нийт хадгаламжийн үлдэгдлийн 83.0 хувийг эзэлж байна. Тэдгээр томоохон хадгаламжийн үлдэгдэлтэй хоршоодын мэдээлэл дараах байдалтай байна.

д/д	Хоршоодын нэр	Нийт хадгаламжийн үлдэгдэл	Нийт хадгаламжид эзлэх хувь
1	Номин юнион	15,052,808.34	43.3%
2	Монкорд	6,084,365.52	17.5%
3	Сидан	2,457,184.93	7.1%
4	Монгол газар гоулд	1,261,855.07	3.6%
5	Алтан давалгаа	987,836.94	2.8%
6	Зоосон мөнгө	677,528.70	1.9%
7	Финком	635,433.77	1.8%
8	Кредит юнион монгол	599,922.85	1.7%
9	Есөн дэлбээ	562,380.98	1.6%
10	Май капитал	553,524.49	1.6%
	Нийт дүн	28,872,841.6	83.0%
	Бусад 138 хоршоо	5,905,790.4	17.0%
	Нийт хадгаламжийн дүн	34,778,632.0	100.0%

Хадгаламж татан төвлөрүүлээгүй 31 хоршоо буюу нийт хоршоодын 17.3 хувь нь зөвхөн өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулж байна.


Хувь нийлүүлсэн хөрөнгө тайлант жилд 7,357,425.1 мянган төгрөг байгаа бөгөөд интервалаар харуулбал дараах байдалтай байна.

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	ХНХ-ийн хэмжээ	Нийт ХНХ-ийн хэмжээнд эзлэх хувь
1	2,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	2,059,097.9	28.0%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	8	1,883,217.2	25.6%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	17	1,085,464.1	14.8%


4	15,000.0-50,000.0 мянган төгрөг	53	1,595,688.2	21.7%
5	10,000.0-15,000.0 мянган төгрөг	30	368,417.0	5.0%
6	5,000.0-10,000.0 мянган төгрөг	34	254,247.5	3.5%
7	1,000.0-5,000.0 мянган төгрөг	36	111,293.2	1.5%
	Нийт дүн	179	7,357,425.1	100.0%

Салбарын хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт хэмжээнд өсөлт гараагүй боловч тайланд онд нэг гишүүний хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн ба 2010 онд гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө 7.4 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 3.0 хувь, хоршоогчдын өмч 3.8 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 2,9 хувийг тус тус эзэлж байна.

Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 2007-2010 онуудын өсөлтийг харуулбал дараах байдалтай байна.



Харин хадгаламж, зээлийн хоршоодын системийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг интервалаар харуулбал дараах байдалтай байна.



Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 2,1 тэрбум төгрөг буюу нийт хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн 28.0 хувийг Номин юнион хадгаламж, зээлийн хоршоо, 10,0 сая хүртэл төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 70 хоршоо, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 0,4 тэрбум төгрөг буюу 5,0 хувь, 10,0-100,0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 100 хоршоо, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 3,0 тэрбум төгрөг буюу 41.0 хувийг, 100-500,0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 8 хоршоо, тэдгээрийн хувь

нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,9 тэрбум төгрөг буюу нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 26.0 хувийг эзэлж байна.

Харин хадгаламж, зээлийн хоршоодын хоршоологчдын өмчийн бүтэц дараах байдалтай байна.

д/д	ХНХ-ийн үзүүлэлт	Хоршооны тоо	Хоршоологчдын өмчийн дүн	Нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь
1	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш	1	815,480.4	21.1%
2	100,000.0-500,000.0 мянган төгрөг	9	2,042,769.3	52.9%
3	50,000.0-100,000.0 мянган төгрөг	6	362,373.5	9.4%
4	10,000.0-50,000.0 мянган төгрөг	35	881,976.7	22.9%
5	1,000.0-10,000.0 мянган төгрөг	89	377,437.0	9.8%
6	1,000.0 мянган төгрөг хүртэл	12	4,214.0	0.1%
7	Хоршоологчдын өмчгүй /алдагдал ихтэй/	27	-624,829.5	-16.2%
	Нийт дүн	179	3,859,421.3	100.0%

Номин юнион хоршооны хоршоологчдын өмч 0.8 тэрбум төгрөг байгаа нь нийт хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хоршоологчдын өмчийн 21.0 хувийг, 100.0-500.0 сая төгрөг хүртэл хоршоологчдын өмчтэй Очир ундраа инвест, Монгол газар гоулд, Есөн дэлбээ, Монкорд, Сидан, Мон сант алдар, Май капитал, Монум, Их наяд кредит зэрэг 9 хоршооны хоршоологчдын өмчийн хэмжээ 2.0 тэрбум төгрөг буюу нийт хоршоодын хоршоологчдын өмчийн 52.9 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын санхүүгийн нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Үүнд:

/мянган төгрөгөөр/

	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ТАЙЛАНГААР
А	АКТИВЫН ЧАНАРЫН БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН	
1	АКТИВЫН ЭРСДЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу) /мянган төгрөгөөр/	2,557,438,297.12 2,534,953,634.89 Дутуу байгуулсан
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 10.1% Хангаагүй
3	ЗЭЭЛИЙН ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ (30 хувиас доош)	30.0% 0.0%
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
4	НИЙТ АКТИВ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ (50-80 хүртэлх хувь)	50%-80% 66.2%
5	ӨБҮХХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 1.1%
6	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас хэтрэхгүй)	5.0% 2.5%
7	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (80 хүртэлх хувь)	80.0% 71.3%
8	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас хэтрэхгүй)	10.0% 1.2%
9	ГИШҮҮДИЙН ХНХ-ИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0% 15.1%
10	ГИШҮҮДИЙН ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА (10 хувиас дээш)	10.0% 7.9% Хангаагүй
11	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	578,913,198.4 1,497,637,327.1

В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ		
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ТҮВШИН (5 хувиас бага)	5.0%	3.4%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР		
14	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (5 хувиас дээш)	5.0%	22.9%
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)		
15	АКТИВЫН ӨГӨӨЖ		1.5%
16	ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ		15.8%
17	ЗЭЭЛИЙН БАГЦЫН ӨГӨӨЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА		23.1%

Хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн хувьд активын эрсдлийн санг 22,484.6 мянган төгрөгөөр дутуу байгуулсан, чанаргүй зээлийн зохистой харьцаа 5.1 хувиар хангагдаагүй, гишүүдийн хоршоологчдын өмчийн харьцааг хангаагүй байна. Харин бусад шалгуур үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна.

ДОЛОО. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫГ АКТИВААР БҮЛЭГЛЭСЭН ТАЛААР


Хорооноос хадгаламж, зээлийн хоршоодод хийж буй газар дээрх шалгалтыг үр өгөөжтэй зохион байгуулах, чанаржуулах, нэг бүлэгт хамаарагдаж буй хоршоодыг харьцуулах замаар тэдгээрийн санхүү, төлбөрийн чадварын байдалд бодит үнэлгээ өгөх зорилгоор хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээгээр нь 4 ангилж дараах байдлаар бүлэглэсэн. Үүнд:

Бүлгийн дугаар	Бүлэглэсэн активын интервал	Бүлэгт багтах ХЗХ тоо	Эзлэх хувь	ХЗХ-ны тоо	
				УБ хотод	Орон нутагт
1	50.0 сая төгрөг хүртэл	107	59.8	33	74
2	50-500.0 сая төгрөг	60	33.5	29	31
3	500.0-1.0 тэрбум төгрөг	7	3.9	6	1
4	1.0 тэрбумаас дээш	5	2.8	5	-
Нийт дүн		179	100.0	73	106

Бодит үнэлгээ өгөхийн тулд бүлэг тус бүрээр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож гаргасан.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2010 оны жилийн эцэст 179 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хоршоодын орон нутгийн байршлыг графикаар харуулбал:



Хадгаламж, зээлийн хоршоодын тоо тайланд онд буурсантай холбоотойгоор гишүүдийн тоо 2079 гишүүнээр буурсан хэдий ч нэг хоршоонд элссэн гишүүдийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодоос 2009 оны зохицуулалт үйлчилгээний хөлс 14,447.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээс 13,910.7 мянган төгрөг буюу 96.3 хувийг Хороо төвлөрүүлсэн байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгө болон татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээг 2006-2010 он хүртэлх 5 жилээр харуулбал дараах байдалтай байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын гишүүдээсээ татан төвлөрүүлсэн хадгаламж болон олгосон зээлийн хэмжээ байнгын өсөлттэй байгаа бөгөөд 2010 онд гишүүдээсээ татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл 34.8 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын 1.3 хувийг, зээлийн өрийн үлдэгдэл 34.9 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.1 хувийг эзэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ системийн хувьд активын өгөөжийн хэмжээ 2009 оны жилийн эцсийн байдлаар 4,81 хувьтай байсан бол тайланд онд 5.3 хувь болж өссөн байна. Үүнд хоршоодын активын өсөлт нөлөөлсөн. Харин өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2010 оны жилийн эцсийн байдлаар 15,42-19,04 хувь болтлоо өссөн байна.

Иймд 2011 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлан, мэдээгээ журмын дагуу гаргаж цаг хугацаандаа ирүүлдэггүй, 2 ба 3 улирал дараалан санхүүгийн тайлан ирүүлээгүй хоршоодын үйл ажиллагааг Хорооны 2006 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага”-ын биелэлтэд анхаарч ажиллах;

2. Хоршооноос ирүүлж буй улирлын санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг хангуулах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хоршооны дарга, тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хороо болон нягтлан бодогч, зээлийн мэргэжилтнээр мэргэжлийн, ур чадвартай хүмүүсийг авч ажиллуулж байгаад анхаарах, тэдгээрт тавих шаардлагыг нэмэгдүүлэх, Монголын хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт мэдээллийн төвтэй хамтран холбогдох сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах;
3. Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны эрх зүйн үндэсийг боловсронгуй болгохтой холбогдуулан хуулийн төслийг хэлэлцэн батлуулахад анхаарч ажиллах;
4. Шинээр батлагдсан хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох заавар, журмуудыг шинэчлэн боловсруулах, боловсронгуй болгох;
5. Газар дээрх болон зайнаас тавих хяналтын чанар үр нөлөөг сайжруулахад анхаарч ажиллах;
6. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд гүйцэтгэх газар дээрх хяналт, шалгалтын ажлыг эрчимжүүлэх;
7. Мэдээллийн баазыг шинэчлэх;
8. Хадгаламж, зээлийн хоршоодын улирлын тайлан мэдээг цахим хэлбэрээр авах программын ажлыг эрчимжүүлж, 2011 онд бүрэн нэвтрүүлэх;

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР